

**ФРЭНЧИЗ КЛИВЕЗ БА МОНГОЛ ХЭЛНИЙ
БИЧИГИЙН ДУРАСХАЛЫН СУДЛАЛ**

Д. Төмөртоого*

Монголчуудын олон зуун жилийн түүх, хэл, соёлын уламжилалыг судалах гол эх сурвалж нь гагцхүү эртний бичигийн дурасхалууд билээ. Монголын түүх, соёлын биет гэрч болсон монгол хэлний бичигийн дурасхалууд нь уйгуржин-монгол, дөрвөлжин, араб, хитад үсэгээр тэмдэглэгдсэн үлджээ. XIX зууны тэргүүн хагасаас эхлэн орос, франц, герман, унгар, польш, америк, япон, хитад, австралийн эрдэмтэд тэдгээр дурасхалуудыг уншин судлаж, олон арван ном зохиол туурвисан байна. Тэдгээрийн дотор Харвардын их сургуулийн профессор, нэрт монголч эрдэмтэн Francis Cleaves-ийн бүтээл онцгой чухал байр эзэлж байна.

Профессор Francis Woodman Cleaves 1911 оны 7-р сарын 14-нд Америкийн Бостон хотод төржээ. 1933 онд Dartmouth их сургуулийг сонгодог утгазохиолын чиглэлээр төгөсөөд 1934 онд Харвард их сургуульд харьцуулсан хэл шинжилгэлийн чиглэлээр магистрийн зэрэг хамгаалжээ. Хоёр жилийн дараа Парисын Сорбони их сургуульд нэрт монголч эрдэмтэн P. Pelliot-ийн дэргэд монгол, хитад, араб судлалын чиглэлээр гурван жил (1936-1938), дараа нь Бээжин дэх Йенчин их сургуулийн дэргэдэх хитад-энэдхэг судлалын хүрээлэнд хитад судлалын чиглэлээр мөн гурван жил (1938-1941) ажиллаж, монгол, хитад судлалын чиглэлээр баялаг материал цуглуулжээ.

Francis Cleaves 1941 онд эх орондоо буцаж очоод, Харвард их сургуулийн Алас дорнод судлалын тэнхимд хитад хэлний багшаар ажиллаж, хажуугаар нь өмөнө эхэлсэн судалгаагаар үргэлжилүүлэн 1942 онд хэлбичигийн ухааны докторын зэрэг амжилттай хамгаалжээ. Тэрвээр дэлхийн хоёр дугаар дайны үед (1943-1945) Номхон далайн тэнгисийн цэрэгийн флотод алба хаагаад, дайн дуусангуут урид нь ажиллаж байсан Бээжингийн хитад-энэдхэг судлалын хүрээлэнд нэг жил ажиллаад эх орондоо, Харвард их сургуульдаа бүрмөсөн эргэж очсон байна. Монгол судлалын чиглэлээр түүний эхлүүлсэн судалгааны ажилыг Харвард их сургуулийн дороно дахины судлалын хүрээлэнгээс өндөрөөр үнэлэн, монгол судлалын чиглэлээр мэргэжилийн хичээл заах зөвшөөрөл олгосон нь Харвардад монголын судлал хөгжихийн эхлэл нь болсон байна. Тэрвээр 1946 оноос 1980 онд тэтгэвэрт гарах хүртэлээ Харвард их сургуульдаа монгол, манж, хитад хэл, монгол утга зохиолын түүх, Юан уласын түүхийн чиглэлээр хичээл заахын зэрэгцээ урид өмөнө огт судлагдаагүй монгол бичигийн олон томоохон дурасхалуудыг судалсан байна.

* Олон Улсын Монгол Судлалын Холбоо

Д. Төмөртгоо

Түүний хамагийн анхны томоохон судалгаа бол хэл бичигийн ухааны докторын зэрэг хамгаалсан сэдэв нь юм. Тэрвээр 1362 онд Индү вангийн дурасхалд зориулан босхосон хөшөөний хитад, монгол бичээсийг галиглан буулгаж, англи орчуулга, үгэсийн хэлхээ, гэрэл зурагийн эх, дэлгэрэнгүй удирдхал, тайлбарын хамт Харвардын Азийн судлалын сэдхүүлийн 1949 оны дугаарт нийтлүүлсэн нь² урид өмөнө судлагдаагүй шинэ дурасхалыг судалсанаараа ч, эрдэм шинжилгээний нихта нимбай, шинэлэг арга зүйгээрээ ч дорнодахины судлаачидын анхааралыг шууд татаж эхэлсэн байна. Дараа нь 1335 онд Чан Йин-жүй-н дурасхалд зориулсан хөшөөний хитад-монгол бичээс,³ Топкапи Сарай музейд буй хитад-монгол зарлиг,⁴ 1338 онд Жигүндэйн дурасхалд зориулсан хөшөөний хитад-монгол бичээс⁵ зэрэг олон сонирхолтой судалгааг Харвардын сэдхүүлийн дугаар алгасалгүй гаргасанаараа хитад-монгол бичээсийн судалгааг үндэслэсэн төдийгүй, дурасхал бичиг судлах нарийн аргазүй боловсоруулан хэрэглэсэн нь зөвхөн монголын судлал төдийгүй, дорнодахины судлалын хүрээнд ч үлгэр загвар болсон байна. Цар хүрээ нь өргөн, утга агуулга нь гүнзгий тийм судалгаа хийхэд өрнийн сонгодог утгазохиоол, дорнын уламжилалт түүх, ялангуяа, монгол бичигийн хэлний гарамгай мэдлэг, түүнчилэн герек, латин, герман, франц, араб, перс, хитад, монгол зэрэг олон хэлний мэдлэг нь чухал түлхэц болсоныг тусхайлан дурдвал зохино. Тийм ч учираас түүний эрдэм шинжилгээний бүтээлүүдийн аргазүй, ач холбогдолыг Францын утгазохиолын академи өндөрөөр үнэлж, 1953 онд Станислас Жулиен (Stanislas Julien)-ы шагналыг хүртээжээ.

Francis Cleaves дээр дурдсан судалгаануудаас гадана мөн монгол, хитад хоёр хэлээр бичсэн 1240, 1346, 1348 оны хитад-монгол бичээсүүд,⁶ 1340 оны Аруг вангийн хөшөөний бичээс,⁷ мөн Бээжин хотын хааны ордны номын санд хадгалагдаж буй “*Тахимдуу ном*”⁸ (*Hsiao Ching*)-ын хитад, монгол хадмал эх зэрэгийг судалсан билээ. Түүнчилэн Ватиканы нууц архивт хадгалагдаж байгаа илхан Авага, Аргун, Газан нарын захидалууд,⁹ Францын Үндэстэний архивт хадгалагдаж байгаа илхан Аргун, Өлзийт нарын захидалыг¹⁰ латин галиг, франц орчуулга, үг хэлцийн тайлбар, үгсийн хэлхээ, гэрэл зурагийн хамт нийтлүүлсэн нь илхадын захидалын иж бүрэн судалгаа болсон байна.

² F. W. Cleaves, The Sino-Mongolian Inscription of 1362 in Memory of Prince Hindu, HJAS 12, 1949, 1-133 + 27 plates

³ F. W. Cleaves, The Sino-Mongolian Inscription of 1335 in Memory of Chang Ying-jüi, HJAS 13, 1950, 1-131 + 35 plates

⁴ F. W. Cleaves, The Sino-Mongolian Edict of 1453 in the Topkapi Sarayi Müzesi, HJAS 13, 1950, 431-446 + 8 plates

⁵ F. W. Cleaves, The Sino-Mongolian Inscription of 1338 in Memory of Jigüntei, HJAS 114, 1951, 1-140 + 32 plates

⁶ F. W. Cleaves, The Sino-Mongolian Inscription of 1346, HJAS 15, 1952, 1-123 + 12 plates; The Sino-Mongolian Inscription of 1240, HJAS 23, 1960, 62-75; The Sino-Mongolian Inscription of 1348, HJAS 27, 1967, 76-102 + 8 plates

⁷ F. W. Cleaves, The Lingji of Aruy of 1340, HJAS 25, 1964, 31-79 + 1 plate

⁸ F. W. Cleaves, The First Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching*, AOH 36, 1982, pp. 69-88; The Second Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching*, *Documenta Barbarum*. Festschrift für W. Heissig zum 70 Geburtstag, Wiesbaden, 1983, 272-281; The Eighteenth Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching*, HJAS 45, 1985, 225-254; The Third Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching*, MS 14, 1991, 117-143; The Fourth Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching*, MS 15, 1992, 137-150; The Fifth Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching*, MS 16, 1993, 19-40; The Sixth Chapter of an Early Mongolian Version of the *Hsiao-ching*, MS 17, 1994, 1-20; An Early Mongolian Version of the *Hsiao-ching*, (The Book of Filial Piety), Chapters Seven, Eight, and Nine. Transcription, Translation, Commentary. Chapters Ten through Seventeen, Transcription, Translation, *The Mongolia Society. Occasional Papers*, Bloomington, Indiana, No 23, 2001, 7-58

⁹ A. Mostaert et F. W. Cleaves, Trois documents mongols des Archives secrètes des vaticanes, HJAS 15, 1952, 419-506 + 8 plates

¹⁰ A. Mostaert et F. W. Cleaves, Les lettres de 1289 et 1305 des ilkhan Aryun et Öljeitü a Philippe le Bel, [= *Scripta Mongolica. Monograph Series 1*], Harvard-Yenching Institute, Cambridge Mass. 1962, VII + 104 + 12 plates

Д. Төмөртгоо

Монгол хэлний эртний дурасхал бичигийн судлалд түүний оруулсан өөр нэг томоохон хувь нэмэр бол 1312 оны “*Bodhicaryavatara-yin tayilburi*”-ийн тухай судалгаа юм. Берлин дэх Турфаны цуглуулгад хадгалагдаж байгаа уул дурасхалыг профессор Francis Cleaves анх удаа эрдэм шинжилгээний галигаар буулгаж, англи орчуулга, үгсийн хэлхээ, хуучирсан үг хэллэг, бүддийн нэр томъёоны тайлбар, гэрэл зурагийн эхийн хамт нийтлүүлсэн нь¹¹ XIV зууны монгол бичигийн хэл, тэр үеийн монгол бичигийн тиг зурлага, нэрт яруу найрагч Чойжи-Одсэрийн бүтээл, бурханы шашины үг хэллэг, нэр томъёо зэрэгтэй нарийвчилан танилцах сайхан боломжи олгосон билээ. Тийм хэмжээний судалгаа хийхэд дундад үеийн монгол хэлний хэл найруулга, үгэсийн сан, бурханы шашин, бүддийн самгард нэр томъёоны асар өргөн мэдлэг шаардлагатай гэдэг нь мэдэж билээ.

Профессор Francis Cleaves урид өмөнө огт мэдэгдээгүй олон шинэ дурасхалыг анхлан судалсаны дотор Техераны музей дэх монгол гар бичмэлүүд,¹² Турфанаас олдсон Сулхарнайн магтаал,¹³ Хар хотоос олдсон зээлийн гэрээ бичиг,¹⁴ Армяны түүхчийн зохиосон “*Нум сумтан ард түмэний түүх*” хэмээх зохиол дахь монгол үг хэллэг, нэр томъёоны тухай¹⁵ зэрэг судалгаа нийтлүүлсэн нь монгол хэлний бичигийн дурасхалын судалгааг ихээхэн баяжуулсан билээ. Мөн монголчуудын ном бичигийн хэрэглээ, эм засалын арга ухааны тухай асуудалаар маш сонирхолтой үгүүлэл бичсэн бий.¹⁶ Түүнчилэн монгол хэлний бичигийн дурасхалуудыг уншин тайлах явцдаа эдүгээ утга санаа нь тодорхойгүй болсон “*jöb ese bol-*”, “*dur-a qočarulča*”, “*daruγa, gerege*”, “*aldar čab*” зэрэг олон үг хэллэгийн тухай сонирхолтой тайлбарууд нийтлүүлсэн байна.¹⁷

Профессор Francis Cleaves 1947-1957 онд Харвардын Азийн судлалын сэтгүүлийн редакцийн гишүүнээр олон жил ажилласан бөгөөд тэр хугацаанд тус сэтгүүлд монголын холбогдолтой олон сонирхолтой үгүүлэлүүд нийтлэгдсэн байна. Мөн 1952 онд нэрт монголч А. Mostaert-ийн хамт *Scripta Mongolica* (Монгол судлалын чуулган) хэмээх тусхай пуваралыг Harvard-Yenching хүрээлэнгийн дэргэд нээж, “*Алтан товч*”¹⁸, “*Эрдэнийн товч*”¹⁹, “*Болор эрик*”²⁰, “*Монгол зурхай, мэргэ төлгө*”²¹ зэрэг сурвалж бичигүүдийн эхийг удирдхал, тайлбар сэлтийн хамт нийтлүүлсэн нь монголын түүхийг өрөнө дахинд танилуулахад ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

¹¹ F. W. Cleaves, *The Bodistw-a Čari-a Awatar-un Tayilbur of 1312 by Čosgi-Odsir*, HJAS 17, 1954, 1-129 + 24 plates

¹² F. W. Cleaves, *The Mongolian Documents in the Musée de Téhéran*, HJAS 116, 1953, 1-107 + 2 plates

¹³ F. W. Cleaves, *An Early Mongolian Version of the Alexander Romance*, HJAS 22, 1959, 1-99

¹⁴ F. W. Cleaves, *An Early Mongolian Loan Contract from Qara Qoto*, HJAS 18, 1955, 1-53 + 4 plates

¹⁵ F. W. Cleaves, *The Mongolian Names and Terms in the History of the Nation of Archers by Grigor of Akanc*, HJAS 2, 1949, 400-443

¹⁶ F. W. Cleaves, *A Chancellery Practice of the Mongols in the Thirteenth and Fourteenth Centuries*, HJAS 14, 1951, 493-526 + 2 plates; *A Medical Practice of the Mongols in the Thirteenth Century*, HJAS 17, 1954, 428-444

¹⁷ F. W. Cleaves, *The Expression Jöb ese bol- in the Secret History of the Mongols*, HJAS 11, 1948, 311-320; *The Expression Dur-a qočarulčaju in the Letter of Öljeitü to Philippe le Bel*, HJAS 11, 1948, 441-445; “*Daruγa and Gerege*” HJAS 16, 1953, 237-259; “*Aldar Čab - Čab Aldar*” HJAS 18, 1955, 225-237

¹⁸ *Altan tobči. A Brief History of the Mongols* by bLobzan bsTanjin, With a critical introduction by the Reverend Antoine Mostaert, C.I.C.M. Edited by F. W. Cleaves, Harvard-Yenching Institute, *Scripta Mongolica* I, Cambridge Massachusetts, 1952, pp. XXV + 1169 + 193

¹⁹ *Erdeni-yin tobči. Mongolian Chronicle* by Sayang Sečen, With a critical introduction by the Reverend Antoine Mostaert, C.I.C.M. Edited by F. W. Cleaves, Harvard-Yenching Institute, *Scripta Mongolica* II, Cambridge Massachusetts, 1969, Part I: IX + 124 + 11 plates; Part II: 2 + 273; Part III: 2 + 298; Part IV: 2 + 270

²⁰ *Bolor erike. Mongolian Chronicle* by Rasipungsuif Sečen, With a critical introduction by the Reverend Antoine Mostaert, C.I.C.M. Edited by F. W. Cleaves, Harvard-Yenching Institute, *Scripta Mongolica* III, Cambridge Massachusetts, 1959, Part I: VII + 384; Part II: 1 + 366; Part III: 1 + 388; Part IV: 1 + 466; Part V: 1 + 348

²¹ *Manual of Mongolian Astrology an Divination*, With a critical introduction by the Reverend Antoine Mostaert, C.I.C.M. Harvard-Yenching Institute, *Scripta Mongolica* IV, Cambridge Massachu-sets, 1969, VI + 127

Д. Төмөртоогоо

Профессор Francis Cleaves-ийн монголын судлалд оруулсан бас нэг чухал хувь нэмэр нь “Монголын нууц товчоон”-ы судалгаа юм. Тэрвээр уул зохиолыг олон жилийн турш уншин судалж, уламаар түүний хамагийн анхны бүрэн англи орчуулгыг өнгөрсөн зууны тавиаад оны сүүлчээр дуусхасан байна. Харин уул орчуулга нийтэд тодорхойгүй нэгэн шалтгаанаар тухайн үедээ хэвлэгдээгүй, бүр хожим наяд оны эхээр хэвлэгдсэн билээ.²² Энэ нь хэдийгээр орчуулгын бүтээл боловч түүнийг маш нарийн эрдэм шинжилгээний бүтээл гэж үзэх бүрэн үндэстэй юм. Тэрвээр *Монголын нууц товчоон*-ы хуучирсан хэл найруулгын өнгө аясыг орчуулгадаа тусгахын тул 1611 онд англи хэлээр орчуулсан Ариун сударын хэл найруулгыг загвар болгосоноос гадана чанартай сайн орчуулахын тул 1813 онд Alex. Fraser Tytler-ийн нийтлүүлсэн “*Essays on the Principles of Translation*” хэмээх алдарт бүтээлд дурдсан орчуулгын үндэсэн зарчмыг мөрдлөг болгосон тухайгаа өөрөө дурдсан бий. Энэхүү бүтээлийн өмөнөх удирдхалд МНТ-ы эх бичигийн судлалын талаар дэлгэрэнгүй үгүүлж, орчуулгынхаа бөлөг хэсэг бүрд холбогдох зүүлт тайлбар хийсэнээс гадана хүний нэр, газар усны нэрийн хэлхээсийг ард нь хавсаргасан байна. Бид академич Ц. Дамдинсүрэнгийн орчуулгыг “*уран сайханы орчуулга*” гэж тодорхойлдог бол Francis Cleaves-ийн орчуулгыг “*эрдэм шинжилгээний орчуулга*” гэж тодорхойлж бүрэн болно. Зохиогч энэхүү бүтээлээ орчуулга, үг хэллэгийн тайлбар гэсэн хоёр ботиоор гаргахаар анхнаасаа төлөвлөж байсан боловч дараагийн ботийг хэвлүүлж амжаагүй нь харамсалтай. Түүний шавь нарынх нь дурдадхалаас үзвэл, тэрвээр МНТ-ы талаар маш өргөн хүрээтэй судалгаа хийсэн бөгөөд уг зохиолын үг хэллэг, тусхай нэрсийн дэлгэрэнгүй тайлбар, үгсийн хэлхээ зэрэг олон бүтээл нь гар бичмэлээрээ үлдсэн байна.

Их эрдэмтэн Francis Cleaves 1995 оны 12-р сарын 31-нд 84 насандаа Нью Хемпшири дэх эдлэндээ таалал төгөсчээ.

Өнгөрсөн зууны дөчөөд оны сүүлчээс эхлэн гуч гаруй жилийн турши туурвисан түүний эрдэм шинжилгээний бүтээлүүд нь зөвхөн Харвардын их сургууль төдийгүй Америкийн Нэгдсэн Улас дахь монгол судлал, түүгээр ч зогсохгүй олон уласын монгол судлалд үнэлж бараангүй хувь нэмэр оруулсан гэдэгийг онцлон тэмдэглэвэл зохино.

Нэрт эрдэмтэн Francis Cleaves-ийн бүтээлүүдтэй улам гүнзгий танилцаж, түүний судалгааны аргазүйгээс суралцах нь өнөөгийн бидний эрхэм зорилго бөгөөд түүний хэвлэгдээгүй үлдсэн арвин баялаг өв нийтийн хүртээл болохыг монгол судлалын ертөнц хүсэн хүлээж байна

²² F. W. Cleaves, *The Secret History of the Mongols. For the First Time Done into English out of the Original Tongue and Provided with an Exegetical Commentary, Vol. I. (Translation)*, Harvard University Press, Cambridge, Massachusetts, London, England, 1982, LXV + 277